



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 374

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ:

1. Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй, 3 нэрийн, нийт 45,934,550.00 (дөчин таван сая есөн зуун гучин дөрвөн мянга таван зуун тавь) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн захирал Б.Батсанчир нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3. Тээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001817
17-r huraldaan.docx

Төрийн өмчийн борлого, зохицуулалтын газрын
2024 оны 02 дугаар сарын 0%-ны өдрийн
377 дугаар тогтоолын хавсралт

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ СЭЛБЭГЭЭР АШИГЛАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын хэмжээ (төгрөг)
1	УАЗ-2206, 58-86 ГАА, 50453076	2006/2006	19,241,500.00	19,241,500.00	-	300,000.00
2	Хьюндай аксент, 72-80 ГАА, КМНСF51FP1U110663	2001/2008	8,693,050.00	8,693,050.00	-	150,000.00
3	Хьюндай аксент, 11-82 ГАА, КМНСCL41VP9U299157	2011/2011	18,000,000.00	18,000,000.00	-	150,000.00
	Нийт үнэ		45,934,550.00 (дөчин таван сая есөн зуун гучин дөрвөн мянга таван зуун тавь)	45,934,550.00 (дөчин таван сая есөн зуун гучин дөрвөн мянга таван зуун тавь)	-	600,000.00 (зургаан зуун мянга)